



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 525

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгаж,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас
балансад шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 19,119,662.30 (арван есөн сая нэг зуун арван есөн мянга зургаан зуун жаран хоёр төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг 9,559,831.15 (есөн сая таван зуун тавин есөн мянга найман зуун гучин нэгэн төгрөг арван таван мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоож Улсын хоёрдугаар төв эмнэлэгт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал Б.Эрдэнэбулган нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны... дугаар сарын...ны өдрийн
 525 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУГАЦАА,
 ҮНЭ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГТ БАЛАНСААС БАЛАНСАД
 ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ /ширхэг/	Балансын нэгж үнэ /төгрөг/	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Цаашид ашиглах хугацаа /жил/	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ /төгрөг/	Шинэчлэн тогтоох нийт үнэ /төгрөг/
1	Компьютер Dell Optiplex 990	2011.12.30	2	1,744,393.7	3,488,787.3	2	872,196.83	1,744,393.65
2	Хөргөгч Б-8	2015.06.30	1	739,675.0	739,675.0	2	369,837.50	369,837.50
3	Нуруу,хүзүүний татлагын ор	2006.12.22	1	11,951,000.0	11,951,000.0	2	5,975,500.00	5,975,500.00
4	УВЧ утлагын аппарат	2007.01.03	1	1,465,200.0	1,465,200.0	2	732,600.00	732,600.00
5	Телевизор LCD TX-32LX800H	2008.12.22	1	1,195,000.0	1,195,000.0	2	597,500.00	597,500.00
6	Сандаг түшлэгтэй HA-264	2012.07.01	1	280,000.0	280,000.0	2	140,000.00	140,000.00
			7	17,375,268.65	19,119,662.30		8,687,634.33	9,559,831.15
	ДҮН				(арван есөн сая нэг зуун арван есөн мянга зургаан зуун жаран хоёр төгрөг гучин мөнгө)			(есөн сая таван зуун тавин есөн мянга найман зуун гучин нэгэн төгрөг арван таван мөнгө)